# ШУУРХАЙ ХЯНАЛТЫН ТӨВИЙН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ БАЗАРВААНЬ ОВОГТОЙ ДӨЛГӨӨНИЙ 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. “УЛСЫН ХИЛЭЭР ХУУЛЬ БУСААР БАРАА ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ НЭВТРҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ”** | | | | | | | |
| 1. | 1.1 Теле хяналтын нэгдсэн систем, камерын хэвийн, найдвартай, аюулгүй байдлыг хангаж ажилласан байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 92.8% | 100% | 2024 оны жилийн эцсийн байдлаар нэгжийн даргын баталсан хуваарийн дагуу газар хороодод суурилуулсан телехяналтын дэд системүүдийн камер болон дагалдах тоног төхөөрөмж, гаалийн хяналтын бүсүүдийн камерын системийн хэвийн ажиллагааг хангах ажлын хүрээнд ажиллахгүй байгаа камер, тоног төхөөрөмжийн шалтгааныг тодруулж хэвийн ажиллагаанд оруулах чиглэлийг тухай бүр өгч ажилласан.<br>• Газар хороодод суурилуулсан телехяналтын системийн бичлэг хадгалах хугацааг уртасгах зорилгоор:<br>- ЧХОУНБГГ-т 12 ширхэг хард<br>- ЗҮГГ-т 12 ширхэг хард диск<br>- УБГГ-т 6 хард диск<br>-СЭГГ-т 24 хард диск тус тус суурилуулсан<br>• УХШИГГ-н бичиг захидал болон ачааны рентген тоног төхөөрөмжүүдийг телехяналтын нэгдсэн системд холбосон.<br>• Увс, Ховд, ГСГГ боомтын импорт талын зорчигчийн болон ачааны рентген аппаратыг ТХНС-д холбосон.<br>• Харьяа гаалийн газар хороодод шинээр Гаалийн хяналтын бүсээр зарлуулах хүсэлт ирүүлсэн 13 аж ахуйн нэгжийн телекамерын байршил, тоо ширхэг, бичлэг хадгалах хугацаа журмын шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт тавьж, шаардлага хангасан ААН-үүдийг ТХНС-д холбож ажилласан.<br>• Боомтын шинэчлэлийн хүрээнд бүтээн байгуулалт хийгдэж буй ЗҮГГ, ГСГГ, Хавирга, Цагааннуур, Булган, Цагаандэл | 2024.01.02-2024.12.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Уул, Арцсуурь, Ханги, Бичигт дэх гаалийн газар, Бүрдүүлэлтийн цахим төвийн телехяналтын камер болон тоног төхөөрөмжийн үзүүлэлтийн судалгааг хийж, камерын байршлын зураг төсөл дээр ажиллан саналаа тусгуулж ажилласан.<br>• Улаанбаатар ГГ, Ханги дахь ГГ, Сайншанд дахь ГГ, Бичигт ГГ, Гашуунсухайт ГГ-т шинээр гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагаа эхлүүлэхээр төлөвлөж 8 буй Аж ахуйн нэгжүүдтэй уулзалт хийж телехяналтын камер болон төхөөрөмжийн үзүүлэлт, тоо ширхэг болон камерын байршлуудыг үйл ажиллагааны технологи дараалалтай уялдуулан төлөвлөх талаар зөвлөгөө чиглэл өгөн ажилласан.<br>• ЧХОУНБГГ-ын харьяа Буянт-Ухаа олон улсын нисэх буудал дахь гаалийн хяналтын бүсээр тусгай үүргийн болон иргэний нислэг хийгдэж байгаатай холбоотой телехяналтын камераар хяналт тавих шаардлага үүсэж байгаа тул СЭГГ-т 2023 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн Б-15 гэрээгээр нийлүүлсэн DELL Streamvault SV-2020E-R14 сервер, дагалдах 14 хард диск болон лицензийг ЧХОУНБГГ-т шилжүүлэх саналыг СХОГ-т дотоод зурвасаар хүргүүлж шилжүүлэхээр шийдвэрлэгдсэн.<br>• Баян-Өлгий ГГ-н Цагааннуур боомтод үйл ажиллагаа явуулж чөлөөт бүсийн суурилуулсан телехяналтын системийг Телехяналтын нэгдсэн системд холбож тохиргоо хийж хяналт тавих боломжтой болгосон.<br>• Мөн зөвлөмжийн 5 шалгуурт дүн шинжилгээ хийн, одоогийн ашиглаж буй шалгуурын параметрийг илүү нарийвчилсан. | | |
| 2. | 1.2 Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн чиглэлээр ашиглагдах бүх төрлийн мэдээллийг төрөлжүүлэн | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100% | 100% | 2024 оны эхний хагас жилийн байдлаар ТХНС-д холбогдсон дугаар таних камераар тээврийн хэрэгслийн хөдөлгөөний сан үүсгэж дүн шинжилгээ хийх, мөн Таблью дата аналитик платформ дээр тээврийн хэрэгслийн бүртгэлийг хяналтын үе шат болгоноор харах боломжтой болгох ажлыг зохион байгуулан ажиллаж байна.<br><br>УХШИГГ болон Увс аймаг дахь гаалийн газрын Боршоо боомтын импорт талын зорчигчийн болон ачааны рентген аппаратыг ТХНС- | 2024.01.02-2024.12.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | цуглуулж, сан үүсгэх, дүн шинжилгээ хийсэн байдал | | | | д холбосноор real-time зорчигч болон тээврийн хэрэгслийн ачаанд дүн шинжилгээ хийн, хяналт тавих боломжтой болсон ба ачааны рентген мэдээллийн санг үүсгэж байна.<br><br>Тус төвөөс илгээсэн зөвлөмжийн дагуу илрүүлсэн зөрчилд холбогдсон иргэн, ААН, бараа, тээврийн хэрэгсэл болон итгэмжлэгдсэн төлөөлөгч гэх мэт мэдээллийг агуулсан санд дүн шинжилгээ хийн, эрсдэл тооцон, өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж байна. | | |
| 3. | 1.3 Мэдээлэлд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр гаалийн хяналт, бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан онилгоо хийн, зөвлөмж илгээсэн байдал | Хэрэгжилт, хувиар | 100% | 100% | Тайлант хугацаанд нэгжийн даргын баталсан хуваарийн дагуу Телехяналтын камер, Таблью дата аналитикийн платформыг ашиглан эрсдэлтэй барааны шалгуурт гарж ирсэн мэдүүлэгт дүн шинжилгээ хийж камерын тусламжтай эрсдэл тооцож, эрсдэлтэй гаалийн мэдүүлэгт КАИС-аас 16 удаагийн зөвлөмж хүргүүлсэн. Уг зөвлөмжийн дагуу ХШГУБ биет үзлэг хийн зөрчил илрүүлж 62,338,247.72 төгрөгийн татварыг нөхөн төлүүлж, 31,169,126.36 төгрөгийн торгууль ногдуулан зөрчлийг арилгаж ажилласан байна. | 2024.01.02-2024.12.10 | 100% |
| 4. | Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн бүх үе шатанд тавьсан хяналт, гэмт хэрэг, зөрчлийг илрүүлсэн байдал, аюулгүй байдлыг хангахад хамтран ажилласан байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100% | 100% | Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн бүх үе шатанд тавьсан хяналт, гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу ЗТГ-т 14 удаагийг болон бусад хууль сахиулах чиглэлийн төрийн байгууллагуудаас (ЦЕГ-ын Экологийн цагдаагийн алба, Хил хамгаалах ерөнхий газар) ирүүлсэн хүсэлтийн дагуу камерын бичлэгийг CD-д хуулан нотлох баримтын бүрдэл хангуулж хүргүүлсэн. | 2024.01.02-2024.12.10 | 100% |
| 5. | Гаалийн байгууллагатай холбоотой гомдол, | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100% | 100% | Гаалийн байгууллагын лавлах тусгай дугаар 1800-1281-ийн үйл ажиллагааг сайжруулах ажлын хүрээнд Юнител ХХК-ийн CallCenter-ийг үйлчилгээг нэвтрүүлж, иргэдээс гаалийн байгууллагатай холбогдох гарцыг нэгтгэн 1800-1281 тусгай дугаарт | 2024.01.02-2024.12.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдээллийг хүлээн авч, шийдвэрлүүлсэн байдал | | | | залгахад уншигдах автомат хоолойн бичлэгийг бичүүлэн, газар хороод руу холбогддог байхаар зохион байгуулж үйл ажиллагаандаа тохируулан нэвтрүүлж ажилласан. | | |
| 6. | Үүрэг даалгаврын биелэлт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100% | 100% | • Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухай бүрт нь хийж хэрэгжилтийг ханган, биелэлтийг танилцуулан ажилласан. Гаалийн шинэчлэлийн хүрээнд хэрэгжиж буй гаалийн хяналт, шалгалтын "ухаалаг гарц" иж бүрдэл бүхий тоног төхөөрөмж нийлүүлэх, угсарч суурилуулах, гэрээний хэрэгжилтийг зохион байгуулах, хилийн боомтуудын бүтээн байгуулалтын ажилтай уялдуулах, гүйцэтгэлд хяналт тавих, иуршиж шалгах, хүлээн авах ажлын хэсэгт орж ажиллаж байна. Тус ажлын хэсгийн эхний хурлаар Ханги боомтод ухаалаг гарц суурилуулах цэгийг тогтоосон.<br>• Ай Ти Зон ХХК-аас эвдрэлтэй тоног төхөөрөмжийг засварлах, хэвийн ажиллагааг хангах ажлын хүрээнд 2024.06.02-ны өдрийн албан бичгээр тоног төхөөрөмжүүдийг засварлаж дуусах хугацааг 2024.09.30-ны өдөр хүртэл сунгаж өгөх хүсэлтэй ирүүлсэн. Энэ хугацаанд эвдрэлтэй тоног төхөөрөмжүүдийг газар хороодоос засварын төв рүү ирүүлэх ажлыг зохион байгуулж, гэмтлийг тодорхойлох, засварлах, газар хороодод буцаан суурилуулах ажлуудыг хийж гүйцэтгэж байна. 2024.12.3-ны өдрийн байдлаар 8 газар хорооны 13 тог баригч, 8 хөргөлтийн системийг бүрэн засварлаж суурилуулан ажиллагаанд оруулсан тухай актыг үйлдэж хүлээлгэн өгсөн байна.<br>• Боомтын шинэчлэлийн хүрээнд БНХАУ-ын буцалтгүй тусламжаар бүтээн байгуулалт хийгдэж буй Дорноговь аймгийн Замын-Үүд дэх гаалийн газрын ачаа тээврийн цогцолбор, Өмнөговь аймгийн Гашуунсухайт дахь гаалийн газрын хяналтын бүсүүдэд суурилуулах телехяналтын камер болон бусад дагалдах тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлт, байршлыг тодорхойлж Сангийн яаманд хүргүүлсэн. Тендерт шалгарсан оролцогчтой Сангийн яамны байгуулсан СЯ/20240102033 дугаартай "Хилийн боомтуудад телехяналтын тоног төхөөрөмж нийлүүлэх" гэрээний дагуу Замын-Үүд боомт болон Гашуунсухайт боомтод телехяналтын камер тоног | 2024.01.02-2024.12.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төхөөрөмжийг угсарч суурилуулах ажил бүрэн дуусч Сангийн яам, Гаалийн ерөнхий газар, Замын-Үүд ГГ болон Гашуунсухайт ГГ-аас хамтарсан ажлын хэсэг байгуулж тоног төхөөрөмж хүлээн авах, туршин шалгах ажилд мэргэжлийн дэмжлэг үзүүлэн, хяналт тавин ажиллаж, ажлын хэсгийн гэрээний дагуу ажил хүлээлцсэн актыг хүлээн авч гүйцэтгэсэн ажлын тайлан болон нийлүүлсэн тоног төхөөрөмжийг хүлээн авсан комиссын актыг СХОГ-т хүргүүлсэн.<br>• Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Гаалийн шинэчлэл”-ийн хүрээнд Боршоо, Сүхбаатар боомтод телехяналтын систем нийлүүлэх 2023 оны Б-15 дугаар гэрээний хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд хяналт тавих, туршиж шалгах, хүлээн авах ажлын хүрээнд 2023 оны 11 сарын 03-ны өдрийн А/519 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг телехяналтын нэгдсэн системийн суурилуулалт холболтын ажил тус бүрийн гүйцэтгэлд хяналт тавин, туршин шалгаж, хүлээн авсан<br>• ГЕГ-ын дэргэдэх Бүрдүүлэлтийн цахим төвд суурилуулах телекамер суурилуулах ажлын хүрээнд нээлттэй тендер зарлаж, тендерт шалгарсан аж ахуйн нэгжтэй 2024 оны 11 сарын 28 өдрийн тоот телехяналтын тоног төхөөрөмж нийлүүлэх, угсарч суурилуулах гэрээ байгуулсан. Уг гэрээний дагуу 52 ширхэг телехяналтын камер, дагалдах тоног төхөөрөмж /сервер-2, хард диск- 8, лиценз-62/нийлүүлж угсралт,суурилуулалт, холболтын ажил хийгдэж бүрэн дууссан.<br>• АТГ-с ирүүлсэн мөрдөгчийн мэдэгдлийн дагуу ЧХОУНБуудал дахь гаалийн газарт гэмт хэрэг гарсан шалтгаан нөхцлийг арилгах зорилгоор Карго терминалын давхар хоорондын шатны хонгилд камер суурилуулах мэдэгдэл ирсний дагуу тус байршилд 1 ширхэг хөдөлгөөнгүй камер суурилуулж тайланг ХБГ-т хүргүүлсэн. Мөн тус мэдэгдлийн дагуу ХБГ-аас ажил сайжруулах төлөвлөгөө батлагдсантай холбоотой 2024.11.01-ны өдрийн 01-2.2/4529 тоот албан бичгээр нийт гаалийн газар хороодод хугацаатай албан даалгавар хүргүүлсэн. Батлагдсан төлөвлөгөөний 1.8-д тусгагдсан ажлын хүрээнд гаалийн газар хороодод үйл ажиллагаа явуулж гаалийн хяналтын бүсүүдийн телехяналтын камер, тоног | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төхөөрөмж, Гаалийн хяналт шалгалтын нийтлэг журмын шаардлага хангаж байгаа эсэх, камерын тоо ширхэг, байршил оновчтой эсэх, нэмэлтээр камер суурилуулах шаардлагатай эсэхэд хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд хяналтын бүсүүдэд албан шаардлага хүргүүлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг газар хороодоос ирүүлсэн. Гаалийн ерөнхий газрын бүтэцийн нэгж, дэргэдэх байгууллага, харьяа гаалийн газар, хороодоос ирүүлсэн тайлан болон Авилгатай тэмцэх газрын мөрдөгчийн мэдэгдлийн дагуу газар хороодод хяналтын камер суурилуулах үнийн судалгаа гарган СХОГ-т хүргүүлэн ажиллаж байна. | | |
| 7. | Ажлын цаг ашиглалт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100% | 100% | Цаг бүртгэлийн нүүр таних төхөөрөмжид тогтмол бүртгүүлж ажилласан. Чөлөөтэй, өвчтэй, тасалсан тохиолдол байхгүй. Гадуур болох хурал зөвлөгөөн, хэлэлцүүлэгт оролцох болон ээлжийн амралтыг ЗДАС программд хүсэлт илгээн нэгжийн даргаар батлуулсан. Ажлын цаг ашиглалтыг үр дүнтэй, гүйцэтгэл сайтайгаар ажилласан. | 2024.01.02-2024.12.10 | 100% |
| **Зорилт 2. “ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ДЭД БҮТЭЦ, ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ”** | | | | | | | |
| 1. | 2.1 Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100% | 100% | Ухаалаг гарцын системийн тоног төхөөрөмжийн ашиглалт, арчилгаа, засвар үйлчилгээг тогтмол хийж байх шаардлага үүссэн тул “Ухаалаг гарцын тоног төхөөрөмж хариуцсан инженер”-ийн албан тушаалд хамаарах албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж, саналыг ХНХ-т хүргүүлсэн. | 2024.01.02-2024.12.10 | 100% |
| 2. | 2.2 Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100% | 100% | Нэгжийн чиг үүрэгт хамаарах хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтийг хангаж ажилласан. | 2024.01.02-2024.12.10 | 100% |
| 3. | 2.3 Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 100% | Өөрийн чиг үүрэгт хамаарах чиглэлээр тохиолдох магадлалтай эрсдэлийг таньж тогтоон, эрсдэлийн сан үүсгэсэн. | 2024.01.02-2024.12.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4. | 2.4 Үндсэн шалгуурт тусгагдаагүй ажил | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100% | 100% | 2009 оны 169 дүгээр тушаалаар батлагдсан "Гаалийн лавлах 1281"-ийн үйл ажиллагааны зааврыг шинэчлэн боловсруулахад өөрийн саналыг тусгасан.<br><br>Цаг үеийн шинжтэй бусад ажлуудыг гүйцэтгэсэн. Үүнд: ГЕГ-ын даргын "Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх аргачлал"-ыг батлах тухай А/238 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан шалгуур үзүүлэлтэд оруулах нэмэлт өөрчлөлтийн саналыг өгсөн. | 2024.01.02-2024.12.10 | 100% |
| 5. | 2.5 Үндсэн шалгуурт тусгагдаагүй ажил | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100% | 100% | Гаалийн байгууллагын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Гаалийн лавлах 1800-1281, ЗГ 11-11, Цахим бүрдүүлэлтийн төвд иргэд, олон нийтээс Гаалийн байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд хагас жилээр дүн шинжилгээ хийж тайланг ЗУГ-т хүргүүлэн ажилласан. | 2024.01.02-2024.12.10 | 100% |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | 1.Гадаад болон дотоодын байгууллагаас зохион байгуулах сургалтад хамрагдах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | ДГБ-ын Ахисан шатны дата аналитикийн сургалтад хамрагдсан. | Гадаад болон дотоодын сургалтад хамрагдаж хууль сахиулах мэдлэгээ дээшлүүлсэн байна. | - Гамшгийн үед гадаадын цэргийн тусламжийг хүлээн авах, хамтра ажиллах чадавхийг сайжруулах чиглэлээр TEMPEST EXPRESS39 олон улсын 10 хоногийн сургалтанд хамрагдан Сертификат авсан. Тус сургалтаар томоохон хэмжээний Гамшгийн үед гадаадын цэргийн тусламжийг хүлээн авах, хамтарч ажиллахад бусад | 2024.01.02-2024.12.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгууллагуудын оролцоо уялдаа холбоог сайжруулах, эрх зүйн орчныг судлахад чухал ач холбогдолттой мэдлэгийг олж авсан.<br>- Таблю дата аналитекийн системийн цахим сургалтанд хамрагдсан. | | |
| 2 | 2.Англи хэлний мэдлэгээ дээшлүүлэх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Англи хэл бие даан сурч, хэлний зохих түвшиний мэдлэгтэй болсон. | Гаалийн хэрэг, гадаад худалдаатай холбогдолтой англи хэлний үгсийн санг нэмэгдүүлэх | TRAM төслөөс боловсруулсан Худалдааг хөнгөвчлөх нэр томъёоны тодорхойлолт гарын авлага болох Англи Монгол тайлбарыг судалж,англи хэлний мэдлэгээ дээшлүүлсэн. | 2024.01.02-2024.12.10 | 100% |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Гаалийн улсын байцаагч — Б.Дөлгөөн / ……………….. / — 2024 оны 12 дугаар сарын 10

*( Албан тушаал )* — *( Нэр, гарын үсэг )* — *( Огноо )*

1250

# ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Б.ДӨЛГӨӨНИЙН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Шуурхай хяналтын төв

## 1.ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 2. “Улсын хилээр хууль бусаар бараа тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй тэмцэх”** | | | | | |
| 1. | Теле хяналтын нэгдсэн систем, камерын хэвийн, найдвартай, аюулгүй байдлыг ханган ажилласан байдал | 60 | 10 | 70 | |
| 2. | Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн чиглэлээр ашиглагдах бүх төрлийн мэдээллийг төрөлжүүлэн цуглуулж, сан үүсгэх, дүн шинжилгээ хийсэн байдал | 51 | 10 | 61 | |
| 3. | Мэдээлэлд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр гаалийн хяналт, бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан онилгоо хийн, зөвлөмж илгээсэн байдал | 50 | 10 | 60 | |
| 4. | Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн бүх үе шатанд тавьсан хяналт, гэмт хэрэг, зөрчлийг илрүүлсэн байдал, аюулгүй байдлыг хангахад хамтран ажилласан байдал | 50 | 5 | 55 | |
| 5. | Гаалийн байгууллагатай холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авч, шийдвэрлүүлсэн байдал | 60 | 10 | 70 | |
| 6. | Үүрэг даалгаврын биелэлт | 60 | 10 | 70 | |
| 7. | Ажлын цаг ашиглалт | 60 | 10 | 70 | |
| **Зорилт 4. “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”** | | | | | |
| 1. | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | 60 | 10 | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2. | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт | 60 | 10 | 70 | |
| 3. | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал | 50 | 10 | 60 | |
| 4. | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт | 60 | 10 | 70 | |
| 5. | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт | 60 | 10 | 70 | |
| | Дундаж оноо: | | | 66.33 | |

## 2.МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийг хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Гадаад болон дотоодын байгууллагаас зохион байгуулах сургалтад хамрагдах | 100% | 15 | |
| 2. | Англи хэлний мэдлэгээ дээшлүүлэх | 100% | 15 | |
| | Дундаж оноо: | | 15 | |

## 3.ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (НЭГЖИЙН ДАРГЫН ҮНЭЛГЭЭ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 7 | |
| 2. | Дүн шинжилгээ хийх | 6 | |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 6 | |
| 4. | Хариуцлагатай байдал | 7 | |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 7 | |
| | Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | |
| 6 | Мэргэжлийн ур чадвар 1. | 7 | |
| | Дундаж оноо: | 6.67 | |

## 4.ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (ХАМТ ОЛНЫ ҮНЭЛГЭЭ)

| Д/д | Хандлага, ёс зүй, ур чадвар | Хамт олны үнэлгээ (0-8) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | 8 |
| 2. | Багаар ажиллах | 8 |

| | | |
|---|---|---|
| 3. | Харилцаа | 8 |
| Дундаж оноо: 8 | | |

## 5.ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно)* | *( 66.33 оноо)* |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | *(15 оноо)* |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Нэгжийн даргын үнэлгээ)* | *(6.67 оноо)* |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | *(8 оноо)* |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | *( ..... оноо)* |
| **Нийт оноо =** (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* )- Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | 96 |

***Үнэлгээ өгсөн:***

***Нэгжийн дарга***
Шуурхай хяналтын төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ........................ /Ц. Хатанболд/

2024.12.10 (огноо)

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:***

***Төрийн жинхэнэ албан хаагч:***
Гаалийн улсын байцаагч ........................ /Б. Дөлгөөн/

2024-12-10 (огноо)

***Үнэлгээг хянасан :***

***Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:***
Дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ........................ /Г. Энхтайван/

10/12, 2024 (огноо)

***Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:***

Хүний нөөцийн хэлтсийн
Гаалийн улсын ахлах байцаагч ........................................ /Ө. Тэгшээ/

2024. 12.20 ............................... *(огноо)*

***Үнэлгээг баталгаажуулсан:***

***Төсвийн шууд захирагч***
Гаалийн ерөнхий газрын дарга ........................................ /Р. Отгонжаргал/

............................... *(огноо)*